



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/306

Есөнбулаг сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Тэрбум мод" тарих үндэсний хөдөлгөөн 108 сая мод тарьж ургуулах арга хэмжээний хүрээнд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 8.000.000 (найман сая) төгрөгийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын Естийн аманд мод худалдан авах ажлыг зохион байгуулан, хэрэгжүүлэх эрхийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т шилжүүлсүгэй.

2. Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын төлөвлөгөөг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүргийг хэрэгжүүлж, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

